

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

1. Батлан хамгаалын сайдад 4 ангийн бүтээгдэхүүн нийлүүлэхээс 3 бүтээгдэхүүнийг бүрэн нийлүүлж, 1 бүтээгдэхүүн тасарч, хүлээсэн үүрэг 75.0 хувьтай байна.

- Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, цэргийн үүрэгтний сургалт явуулах, улсын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах, даалгаваржуулах ажлууд бүрэн хийгдэв.

Мөн Батлан хамгаалах зорилт бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, Монгол Улсын өрлөг жанжин Г.Дэмидийн мэндэлсний 110 жилийн ой тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулав.

Харин аймгийн Засаг даргын Тамгын Газрын Цэргийн штабт иргэний хамгаалалт хариуцсан албан тушаалтан ажиллуулах заалт цалингийн сангийн хүрэлцээгүйгээс болж биелэгдсэнгүй.

2. Байгаль орчин аялал жуулчлалын сайдад: 4 бүтээгдэхүүний ангийн 4 бүтээгдэхүүнийг 100 хувьтай биелүүлсэн болно.

Улсын төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 20 га-д, байгалийн сэргэн ургалтанд туслах ажлыг 80 га-д тус тус гүйцэтгэж эхний жилийн амьдралт 78,8%-тай чанар сайн байна.

Улсын төсвийн хөрөнгөөр 5 булаг, Байгаль хамгаалагч иргэдийн оролцоотойгоор 35 булаг нийт 40 булгийн эхийг хашиж хамгаалалтанд авлаа.

Архангай аймгийн аялал жуулчлалыг 2010-2020 хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулаж, аймгийн Засаг даргын дэргэд аялал жуулчлалын зөвлөл байгуулан ажиллаж байна.

Ашигт малтмалын ашиглалтын лицензтэй талбайд олборлолт явуулсан иргэн аж ахуйн нэгж байгууллагуудаас усны төлбөрөөр 42829,0 сая төгрөг, ус, рашаан ашигласны төлбөрөөр 36971,0 сая төгрөг 79800,0 нийт төгрөгийн ус ашигласны төлбөрийн орлого төвлөрсөн болно.

Малчид, тариаланчид, Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг 1,3,7 хоног, сарын урьдчилсан, улиралын төлөв, аюултэй үзэгдлийн сэрэмжлүүлэг, анхааруулга болон тусгай хэрэгцээний ханган ажиллаж байна.

Гэрээнд туссан үйлчилгээний чанар үр ашиг дээшлээд байна

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчтай 2010 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар хийсэн гэрээнд 3 ангийн 15 нэрийн бүтээгдэхүүн тусган ажиллаж гэрээний үүрэг 100% биелүүлэв.

Сургуулийн өмнөх боловсрол бүтээгдэхүүний анги дотроо 5 бүтээгдэхүүнийг улсын төсвөөс 1.743.955.0 төгрөгөөр, ерөнхий боловсролын 2 дахь бүтээгдэхүүний анги дотроо 6 бүтээгдэхүүнийг 8.563.894.9 төгрөгөөр, соёл урлаг гэсэн 3 дахь бүтээгдэхүүний ангид 629.010.4 төгрөгөөр тус тус санхүүжүүлэн ажилласан.

4 багт цэцэрлэгийн салбар ажиллуулан 105 хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлж байна.

Өлзийт сумын сургуулийн 75 ортой дотуур байрны барилга шинээр 434.4 сая төгрөгөөр Япон улсын “Өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд барьж ашиглалтанд оруулсан. Хотонт, Хашаат суманд 150, 75 ортой дотуур байрны барилгыг шинээр барих ажлыг эхлүүлээд байна.

БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 15 сумын сургуулийн дотуур байр, түүнд амьдардаг 942 хүүхдэд ариун цэврийн хэрэглэл, ном, тоглоомын багц бүхий 19.4 сая төгрөгийн эд зүйлсийн дэмжлэг үзүүлсэн.

2008-2009 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 712 хүүхэд ЕБС-д, 36 хүүхэд цэцэрлэгт сурч хүмүүжиж байсан бол 2010-2011 оны хичээлийн жилд ЕБС-д 900, цэцэрлэгт 44 болж нэмэгдсэн байна.

“Үдийн цай” хөтөлбөрт төрийн болон төрийн бус өмчит нийт 35 сургуулийн 1-5-р ангийн 10908 хүүхэд 2010 оны эхний 5 сард, 10156 хүүхэд 2010 оны 4 сарын хугацаанд хамрагдаж байна.

4. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдтай аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн талаар 2010 онд байгуулсан гэрээнд 6 бүтээгдэхүүн тусгагдсан байна. 1-р бүтээгдэхүүний ангийн Хүн амын хөгжлийн дэмжих үйл ажиллагаанд 5 үйл ажиллагааг тусган 2.0 сая төгрөгийн өртөгөөр 100%, 2-рт Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 14552.6 сая төгрөгийн өртөгөөр 100%, 3-рт Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагааг 892863,5 мян төгрөгөөр гүйцэтгэж 95.3%, 4-р ангийн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг 4111914.7 сая төгрөгөөр 78.2%, 5-р ангийн орон нутгийн ахмадын байгууллагыг дэмжих үйлчилгээг 6443,8 мянган төгрөгөөр 100%-гүйцэтгэсэн байна. Мөн ахмадын байгууллагын үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 4.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний хүрээнд аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлээгүй 1627 иргэдийг бүртгэж нэгдсэн мэдээллийн сантай болсон, орон нутгийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн сургалтанд 612 иргэнийг хамруулан түүний 59,9 % нь ажлын байраар хангагдсан, жижиг зээлийн үйлчилгээний хүрээнд 705 ажлын байр шинээр бий болсон байна.

Нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгогдох тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь чирэгдэлгүй шуурхай олгосон.

Нийгмийн даатгалын санд 4765381,4 мян төгрөг оруулахаас 5069500,0 мянган төгрөг төвлөрүүлж 106.4 %-ийн биелэлттэй байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн төсвийн ерөнхийлэн захирагчтай байгуулсан гэрээний биелэлт **94.7%**-ийн гүйцэтгэлтэй биелэсэн байна.

5. Хууль зүйн дотоод хэргийн сайдтай Засаг даргын байгуулсан гэрээний хугацаанд нийлүүлбэл зохих нийт 39 бүтээгдэхүүн нийлүүлхээс 36 бүтээгдэхүүнийг бүрэн хэрэгжүүлж, гэрээний биелэлт 92.5 хувьтай биелэсэн.

Эрдэнэмандал суманд шинээр цагдаагийн хэсгийн /кобан/ байрыг бариулж 7 дугаар сард ашиглалтанд оруулсан, Цагдаагийн газар аймгийн төвд албан хаагчийн 2 орон сууц, Төвшрүүлэх, Өгийнuur сум бусад 17 суманд хэсгийн төлөөлөгч, цагдаагийн албан хаагчийн орон сууцны засварыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар бүрэн хийж ашиглалтанд оруулсан.

2010 онд гомдол мэдээлэл 3975, үүнээс гэмт хэргийн шинжтэй 831 өргөдөл мэдээлэл хүлээн авсан нь өнгөрсөн онтой харьцуулахад 164 буюу 20,8 хувиар өссөн байна. Цагдаагийн газрын тайланг аймгийн “Тамир” телевиз, “Архангай амьдрал” сонинд нийтэлж нэвтрүүлэн ажилласан.

Булган, Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай аймгуудын цагдаагийн газар, хэлтэстэй хамтарсан “Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээ, хамтын ажиллагаа” сэдэвт бүсчилсэн зөвлөгөөнийг 2010.10.12-13-ны өдөр манай аймагт 60 хүн оролцлоо. 13 зүйл бүхий уриалга гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэмт хэрэгт өртөж болзошгүй, хараа хяналтгүй, бүтэн өнчин, үрчлүүлсэн, нэн ядуу амьдралтай 115 хүүхдийг шинээр хяналтанд авч бүртгэн, хүмүүжил төлөвшилд нь анхаарч, сургуулийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш, өсвөрийн цагдаагийн бүлэгтэй хамтран ажилласнаар 60 хувь нь засарч төлөвшин, 32 хүүхэд насанд хүрч хасагдан, одоо 40 хүүхэд бүртгэл хяналт тогтоон сар тутам уулзаж, зөвлөгөө өгч ажиллаж байна.

2010 онд эргүүлийн цагдаагийн орон тоо батлагдсан боловч цалингийн фонд хүрэлцээгүйгээс эргүүлийн цагдааг томилож ажиллуулаагүй болно.

6. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад бүтээгдэхүүний 5 ангийн 16 бүтээгдэхүүн нийлүүлэхээр гэрээ хийснээс 82.6 хувийн биелэлттэй байна.

Тайлант онд 1.3 сая толгой малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад, 0.8 сая толгой малыг паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх угаалга туулга, боловсруулалтад хамруулж төлөвлөгөөт ажлыг 100.8-114.0 хувиар биелүүлэв.

“Малын тэжээл” хөтөлбөрийн хүрээнд 2010 оныг “Ногоон тэжээл тариалтыг нэмэгдүүлэх жил” болгон ажилласнаар 1300 га-д тэжээлийн ургамал тариалж, 3244 тн ургац хураан авсан нь урьд оноос тарьмал тэжээл бараг 10 дахин нэмэгдэв.

Улсын төсвийн 1.0 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалттай Техник дундын үйлчилгээний төвийг орон нутгийн өмчит үйлдвэрийн хэлбэрээр байгуулав.

Мөн Архангай аймгийг хөдөө аж ахуйг хөгжлөөрөө загвар аймаг болгох төсөл боловсруулан ажиллаж эхлэв.

7. Эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээний биелэлт:

Эмнэлгийн тусламж үйлчилгээний анхдагч, хоёрдогч лавлагаат тусламж үйлчилгээг нийт 31 эмнэлэг үйлчилгээний байгууллагад нийт 1054 эмнэлгийн ажиллагсад ард иргэдэд үзүүлж байна. Тайлангийн хугацаанд нийт 13 их эмчийг шинээр орон тоогоор авч ажиллуулснаар их эмчийн хангалтын хувь 7.1 хувь нэмэгдэж, сумдын эмнэлгүүд 100 хувь их эмчтэй болсон..

Эрүүл мэндийн талаар хүлээсэн үүргийг 9 бүтээгдэхүүн тус бүрээр үнэлбэл:

Эхийн эрүүл мэндийн үйлчилгээ - 81.2%, хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээ-81.5%, халдварт өвчний танадалт судалгаа, дархлаажуулалт-96.5%, халдварт бус өвчний талаар -60.0%, харилцаа холбоо, дотоод сүлжээ ашиглалт -100.0%, оношийн зөрүү-100.0%, нийт нас баралт -0.0%, хүний нөөцийн хангалт-100.0%, эмийн хангамж-96.0% иар биелэсэн байна.

2010 онд манай аймагт 2045 эх төрж, өмнөх оноос 56 тохиолдлоор нэмэгдэж, жирэмсний хүндрэл 5 хувиар буурч эхийн эндэгдэл 1 гарч 100 000 амьд төрөлтөнд 48 болж нэмэгдсэн ч улс аймгийн дундачаас доогуур байна.

Нийт төрөлтийн 57,7 буюу 1181 төрөлт нь аймгийн НЭ-ийн төрөх тасагт байгаа нь жирэмсэн төрөх үедээ эрсдэл бүхий эмэгтэйчүүдийг оношлон илрүүлж төрүүлж байгаатай холбоотойгоор Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн ачааллыг ихэсгэж байна.

Аймгийн хэмжээнд 0-15 насны хүүхдийн эндэгдэл 66-с 68 болж 2 тохиолдлоор нэмэгдсэн. 0-1 насны хүүхдийн эндэгдэл 53-аас 51 болж 2 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна.

Эхийн эндэгдлийг 2005-2010 онд бууруулах аймгийн стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг бүтэн жилээр гарган дүгнэлт хийж зөвлөмж өгч ажилласан.Төлөвлөгөөний хэрэгжилт 88-94 хувьтай байна.

Төрөх тасагт эндсэн нярай, хүүхдийн тасагт эндсэн хүүхдийн эндэгдлээр клиник патоанатомийн конференци хийж эндэгдлийн шалтгааныг ярилцаж авах арга хэмжээ, анхаарах зүйл, хийх ажлаар үүрэг даалгавар өглөө. 2010 онд төрөх тасагт эндсэн нярай, хүүхдийн тасагт эндсэн хүүхдийн эндэгдлээр клиник патоанатомийн конференци хийж эндэгдлийн шалтгааныг ярилцаж авах арга хэмжээ, анхаарах зүйл, хийх ажлаар үүрэг даалгавар өглөө.

Эх хүүхдэд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, өвчлөл, эндэглийг бууруулах үүднээс ЭМГ, НЭ, өрхийн эмнэлгүүдийн хооронд гурвалсан гэрээг байгуулан ажиллаж тайлангийн хугацаанд 2 удаа уулзалт хийн тулгамдсан асуудлаа хэлэлцэн цаашид хэрэгжүүлэх, шийдвэрлэх арга замыг хэлэлцэн ажилласан.

Шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт хийх хэрэгцээний хүрээнд НЭ-ийн НҮЭМ-ийн клиникт 21 нэр төрлийн 62 349 352 төгрөгний 33 аппарат, Хүүхдийн тасагт 13 нэр төрлийн 26 152 193 төгрөгний 14 аппаратын хангалтыг хийж эмчилгээ үйлчилгээнд ашиглуулж байна. НЭ-ийн эхчүүдийн амрах байрыг 4 607 000 төгрөгөөр тохижуулж, цэвэр бохир усны байгууламжийг 50 сая төгрөгөөр засварласан.

Гэрээгээр хүлээсэн үүргийн **биелэлт -79.4%**

8. Үндэсний Статистикийн хорооны даргад 17 бүтээгдэхүүн нийлүүлэхээс бүгдийг 100.0 хувиар нийлүүлэв. Үүнд:

Хүн ам, орон сууцны тооллог, мал тооллогыг хугацаанд зохион байгуулж, ажиллах хүчний судалгаа, өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа болон төслийн шугамаар хийгдэж байгаа судалгааг хугацаанд журмын дагуу явуулж ирлээ.

Мөн захиргааны статистик мэдээллээр 22 төрлийн мэдээллийг сар, улирлаар 48 аж ахуйн нэгж, байгууллагаас давхардсан тоогоор 376 удаа авч аймгийн удирдлагыг мэдээллээр ханган, иргэдэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэж байна.

